



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 01 өдөр

Дугаар Б/106

Хэрлэн сум

Б.Оюундарийг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дугаартай тушаалаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын 2.1 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" 487 дугаар тогтоолын хавсралт, Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам", Засгийн газрын 2024 оны "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох тухай" 82 дугаар тогтоолын хавсралт, Барилга хот байгуулалтын сайдын 2017 оны 200 дугаар тушаалаар батлагдсан "Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны Арван наймдугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Баатархуягийн Оюундарийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Олон нийт, үйлдвэрийн барилга, дэд бүтцийн бодлого, зураг төсөл хариуцсан мэргэжилтний албан тушаалд 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.

2.Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Д.Баярхүү

Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт,

2.

бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Б.Мөнхжаргал

Байгаль орчин, уул уурхай, хүнд үйлдвэрийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн

Т.Баяртуяа

Нярав

3.Б.Оюундарийн үндсэн цалинг ТЭ-8 зэрэглэл, 1,399,000 (нэг сая гурван зуун ерэн есөн мянга) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 4 хувиар, орон нутагт ажилласны нэмэгдлийг 40 хувиар, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 10 хувиар өдрийн хоолны хөнгөлөлтийг 15,000 төгрөгөөр болон бусад нэмэгдлийг тус тус тооцож олгохыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4.Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэн, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг Б.Оюундарьд үүрэг болгосугай.

ДАРГА



А.ЖАРГАЛСАЙХАН

